



*Bayangol Hotel*

*Since 1964*

*1964 Since*

**“БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК  
ЖИЛИЙН ТАЙЛАН  
2020 ОН**



Улаанбаатар хот



## ЭРХЭМ ЗОРИЛГО

”Баянгол зочид буудал” хувьцаат компани нь зочдоо дээдэлсэн,  
зочин бүртээ чин сэтгэлээсээ үйлчилдэг байгууллага”





## КОМПАНИЙН ТУХАЙ

Баянгол Зочид Буудал ХК-нь 1964 онд анх байгуулагдсан бөгөөд 1991 онд хувьцаат компани болж хувийн хэвшлийн аж ахуйн нэгж болон өөрчлөгдсөн.

2003 оны 6 дугаар сард явагдсан Улсын мэргэжлийн хяналтын алба, Дэд бүтцийн яам, Аялал жуулчлалын газраас буудлуудын зэрэглэл тогтоох үзлэгээр 4 одтой зочид буудал болсон байна.

Одоогийн байдлаар 360 орчим зочин хүлээн авах, таван ангилалын 205 өрөөтэй. Рестораны хувьд 300-450 хүн зэрэг хүлээн авах “Баянгол ресторан”, үндэсний хоолоор үйлчлэх “Монголын нэг өдөр ресторан”, дээд зэрэглэлийн виноны “Wine House” кафе-баараар үйлчлэхээс гадна зочны угаалга, өрөөний үйлчилгээ, үсчин гоо сайхан, саун, фитнес интернет зэрэг 20 гаруй төрлийн дагалдах үйлчилгээг зочдод үзүүлж байна.

### Алсын хараа

“Баянгол зочид буудал” хувьцаат компани нь зочлохуйн үйлчилгээний салбарт тэргүүлэх чиглэл баримтлан, гадаад дотоодын байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, чадварлаг мэргэжлийн баг хамт олныг бүрдүүлэн орчин үеийн дэвшилтэт технологиудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн олон улсын үйлчилгээний стандарт болон үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжид нийцсэн “Баянгол брэнд”-ийн үйлчилгээг буй болгоно.

### Зорилт

Зочид гийчдийн ая тухтай орчныг бүрдүүлэх хөрөнгө оруулалт хийж, мэргэжлийн туршлагатай МЭРГЭШСЭН баг хамт олон үйлчлүүлэгч бүрийн сэтгэлд нийцсэн шинэлэг үйлчилгээгээрээ буудлын ор ашиглалтыг бууруулахгүйгээр, борлуулалтын нийт орлогыг 8,5 тэрбум төгрөг болгож, татварын өмнөх ашгийг өнгөрсөн оны хэмжээнд байлгахаар зорьж ажилласан.



## КОМПАНИЙ БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

- Баянгол Зочид буудал нь 360 зочин хүлээн авах, таван ангиллын 205 өрөө, 300-450 хүн хүлээн авах боломжтой Баянгол ресторан, Монголын нэг өдөр ресторан, Ази-Европ хоолны ресторан, дээд зэрэглэлийн виноны Wine House кафе-баар, зочны угаалга, өрөөний үйлчилгээ, үсчин гоо сайхан, интернет зэрэг 20 гаруй төрлийн дагалдах үйлчилгээг зочдод үзүүлж байна.
- 2020 онд Covid-19 ын улмаас хүнд нөхцөл байдалд үйл ажиллагаагаа явуулсан ч ДЭМБ, УОК, ЭМЯ, НОК, ХӨСҮТ, ЗӨСҮТ, ЦЕГ, МХГ, НЗДаргын захирамж, зөвлөмжийг удирдлага болгон ажиллаж 2020 оны 11 сард Монгол Улсын “Хөл бөмбөгийн шигшээ баг”-ийн тамирчдыг хүлээн авч байрлуулж ажилласан.
- Мөн УОКомиссын хүсэлтээр тус байгууллагын шуурхай штабын алба хаагчдад хүргэлтийн хоолоор үйлчилсэн.
- Хоол хүргэлтийн газруудтай хамтран захилагат хоолнууд гаргаж онлайн үйлчилгээг нэвтрүүлсэн.
- Ажлын байраа хадгалж ажилчин, албан хаагчиддаа мөнгөн болон материаллаг дэмжлэг үзүүлж Женко группийн зүгээс "Дархлаа дэмжих 1,2,3 аян" -г зохион байгуулж ажиллагсдаа бүрэн хамруулсан.



## БҮТЭЭГДЭХҮҮН ҮЙЛЧИЛГЭЭ САЙЖРУУЛАЛТ

“БАЯНГОЛ РЕСТОРАН”-НЫ ӨГЛӨӨ ЦАЙНЫ ШИНЭ ЦЭС



# “МОНГОЛЫН НЭГ ӨДӨР” РЕСТОРАН



Bayangol Hotel

*Business lunch set*  
12:00-15:00 цагийн хооронд

## “Монголын Нэг Өдөр” Ресторан



### МЯГМАР, ПҮРЭВ ГАРИГУУДАД

#### СЭТ 1

ЦУЙВАН  
МӨӨГТЭЙ ХАР ШӨЛ  
СҮҮТЭЙ ЦАЙ  
БУЛОЧКА, МАСЛО

#### СЭТ 2

ШАРСАН ЭЛЭГ  
БИНТЭЙ ХАР ШӨЛ  
СҮҮТЭЙ ЦАЙ  
БУЛОЧКА, МАСЛО

9999 ₮

### ДАВАА, ЛХАГВА, БААСАН ГАРИГУУДАД

#### СЭТ 3

ХУУШУУР  
ГООЛИНГОО НОГООН ШӨЛ  
СҮҮТЭЙ ЦАЙ  
БУЛОЧКА, МАСЛО

#### СЭТ 4

МӨӨГТЭЙ ХУУРГА ХОНИНЫ МАХТАЙ  
ТАСАЛСАН ГУРИЛТАЙ ШӨЛ  
СҮҮТЭЙ ЦАЙ  
БУЛОЧКА, МАСЛО



“Монголын Нэг Өдөр” Ресторан  
Баянгол зочид буудал “Б” корпус 2-р давхарт



11-312255  
94099585

“Монголын Нэг Өдөр” рестораныг шинэчлэн засвар шинэчлэлт хийж, зочид үйлчлүүлэгчдийнхээ дархлааг дэмжих зорилгоор ланч сет санал болгож байгаа нь үйлчлүүлэгчдийн таашаалд нийцээд байна.

# “WINE HOUSE ” РЕСТОРАН

ШИНЭЧЛЭГДСЭН ЦЭСНИЙ АМТЛАГ САЙХАН ХООЛНУУДАЙ ТӨГС ЗОХИЦОХУЙЦ ОЛОН ТӨРЛИЙН ДАРСНЫ СОНГОЛТТОЙГООР ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИДДЭЭ ҮЙЛЧИЛЖ БАЙНА.



## Mixed grilled and Fried meat platter



### WINE HOUSE RESTAURANT

Ширээ захиалга: 9870-3366, 9409-9585

70'000



## Fried salmon White



### WINE HOUSE RESTAURANT

Ширээ захиалга: 9870-3366, 9409-9585




## Cheese Cake



### WINE HOUSE RESTAURANT

Ширээ захиалга: 9870-3366, 9409-9585

40'000T



## Cheese Platter

"Wine House" restaurant  
Bayangol hotel,  
Tower "A" ground floor  
9409-9585



35'000T



## КОМПАНИЙН 2020 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛЫН ХУРААНГУЙ

- “ОРОН СУУЦНЫ УРЬДЧИЛГААНД ЗОРИУЛСАН УРТ ХУГАЦААТАЙ, ХҮҮГҮЙ ЗЭЭЛ” компаниас авах эрхийг Ажлын үр дүн, бүтээлч хөдөлмөр, урт хугацаанд үр бүтээлтэй ажилласан хөдөлмөрч ажилтандаа гардуулан өгсөн.
- Дэлхийн нийтээр тархаад байгаа цар тахлаас (covid-19)-аас иргэдээ хамгаалах, урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах үйлсэд ажилчдын нэг өдрийн цалингаа хандивласан.
- УОК, ЭМЯ-наас гаргасан заавар зөвлөмжийн дагуу COVID-19 вирусын халдвараас урьдчилан сэргийлэхийн тулд ажлын байранд ариутгал, халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээг тогтмол хийж, ажилтан бүрийг цар тахлын халдвараас хамгаалах ажлыг байгууллагын зүгээс байнга зохион байгуулсаар байна.
- Ажлын байрыг хадгалан ажлын цагийг богиносгож, ажилчидаа Засгийн газрын “Дэмжлэг”-т бүрэн хамруулсан.
- Хамтран ажиллагч байгууллагуудын түрээсийн төлбөрийг цар тахлын үед 4 өөс 12 сар хүртэлх хугацаанд 50%-100% хүртэлх хөнгөлөлтийг үзүүлж дэмжиж ажилласан.
- Байгууллагын зусланд ажилчдаасаа 9 ажилтныг гэр бүлээрээ зуны цагт байрлаж агаарт амьдрах нөхцөлөөр тогтмол хангадаг.





## КОМПАНИЙН ЗАСАГЛАЛЫН ТАЛААР

Компанийн засаглалын кодексыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх зорилгоор засаглалын дараах 5 журмыг боловсруулж батлан дотоод үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна. Үүнд:

- “ ТУЗ-ын үйл ажиллагааны журам”
  - “Ногдол ашгийн бодлогын журам”
  - “ Дотоод хяналтын журам”
  - “ Хувьцаа эзэмшигчдийн хурал зарлан хуралдуулах журам”
  - “ Мэдээллийн үйл ажиллагааны журам”
- 
- Баянгол зочид буудал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 3 гишүүн нь хараат бус гишүүд ажиллаж байна. Компанийн хуулийн дагуу жил бүр Хувьцаа Эзэмшигчдийн хурлаа зарлаж тухайн жилийн борлуулалтын ашиг, эдийн засаг, санхүүгийн тайлан мэдээгээ хувьцаа эзэмшигчиддээ танилцуулдаг
  - Хувьцаа эзэмшигч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага болон бусад сонирхогч талуудын хоорондох харилцааны багц асуудлууд болон компанийн зорилтыг тодорхойлох, хэрэгжүүлэх бүтэц, арга зам, хэрэгжилтийг хянах хяналтын тогтолцоог тодорхойлдог чухал ойлголт юм. Үүний дотор “ компанийн засаглалын кодекс” буюу компаний удирдлага, зохион байгуулалтын зарчмууд голлох үүрэг гүйцэтгэж байна.



## КОМПАНИЙН БҮТЭЦ ҮЙЛ АЖИЛЛАГАА

- “Баянгол зочид буудал” ХК-ийн хувьд компанийн засаглалын кодексийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилладаг.

### Хувьцаа эзэмшигчид

- Компаний хөрөнгө оруулагчид
- ТУЗ-ийн гишүүдийг сонгох, чөлөөлөх
- Хуулийн дагуу эрхээ бүрэн эдлэх

### ТУЗ

- Компаний стратеги
- Гүйцэтгэх удирдлагыг удирдамжаар хангах
- Гүйцэтгэх удирдлагад хяналт тавих
- Хувьцаа эзэмшигчийг төлөөлнө

### Гүйцэтгэх удирдлага

- Стратегийг хэрэгжүүлнэ
- Өдөр тутмын үйл ажиллагааг зөв зохистой зохион байгуулна
- ТУЗ болон ХЭ-ийн өмнө ажлаа тайлагнана

“Баянгол зочид буудал” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт 9 гишүүний 3 нь хараат бус гишүүд бөгөөд Компанийн хуулийн дагуу жил бүр Хувьцаа Эзэмшигчдийн хурлаа зарлаж тухайн жилийн борлуулалтын ашиг, эдийн засаг, санхүүгийн тайлан мэдээгээ хувьцаа эзэмшигчиддээ танилцуулж тайлагнаж хэвшсэн байгууллага юм.

Хувьцаа эзэмшигчдийн хурал  
/Meeting of the Shareholders/

Төлөөлөн удирдах зөвлөл  
/Board of Directors's/

Гүйцэтгэх Захирал  
/Executive Director

Санхүү эрхэлсэн дэд  
захирал/Deputy Director of  
Finance

Санхүү хангамжийн  
алба  
/Financial Department/

Ерөнхий менежер  
/General manager/

Хүний нөөцийн алба  
/Human Resource/

Борлуулалт  
маркетингийн  
алба/Sales and  
Marketing  
department/

Хоол  
үйлдвэрлэл  
үйлчилгээний  
алба  
/Food&Beverage  
Department/

Буудлын  
алба  
/Rooms  
Division/

Инженер  
техникийн  
алба  
/Engineering  
Department/

Дюти  
менежерүүд  
/Duty  
Manager/

Харуул  
хамгаалалтын  
алба  
Security service

**ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА**  
ТУЗ-ийн бүтэц, гишүүдийн ур чадвар, ажлын туршлага,  
тэдгээрийн компанид үзүүлж буй хувь нэмэр

**ООС-еéí äàðãà**

<b>Нэр</b>	<b>Базарын Аюуш</b>
Боловсрол	МУИС, Оросын ЭЗ-ийн академи
Мэргэжил	Худалдааны нягтлан бодогч, Эдийн засагч
Ажлын туршлага	1975-1977 ТТХЕГазар орлогч ня-бо 1977-1994 МУИС-д багш 1994-2012 СЗХороонд хэлтсийн дарга, газрын орлогч дарга, даргын зөвлөх 2012 оноос Сангийн яамны зөвлөх
Цол зэрэг:	Эдийн засгийн ухааны доктор /P.H.D/ Алтан гадас одон, Санхүү банкны тэргүүний ажилтан, Бүртгэл статистикийн тэргүүний ажилтан, Хөрөнгийн зах зээлийн хүндэт тэмдэг
Компанид үзүүлж буй хувь нэмэр	--ТУЗ-ын дарга, --Шагнал урамшуулал, цалин хөлсний хорооны дарга

## ТУЗ-ийн гишүүд

Нэр	Х.Цэндбаяр	Х.Баттуул	Билли Лим	М.Золжаргал	З.Цэрэнчимэг
Боловсрол	Багшийн дээд сургууль, Удирдлагын академи	Багшийн дээд сургууль	Политехникийн дээд сургууль	БНСУ, Хандонг их Сургууль, Англи Улсад магистр хамгаалсан	Боловсрол
Мэргэжил	Багш, Бизнесийн удирдлага	Биеийн тамирын багш	Инженер	Аялал жуулчлалын зохицуулалтын менежмент	Нябо, эдийн засагч, Бизнес удирдлагын арга зүйч
Ажлын туршлага	--1985-1997 34р дунд сургууль багш --1997-1998 Женко компани менежер --1998-2001 Countryside restaurant Гүйцэтгэх захирал --2000 оноос БГЗБ ХК гүйцэтгэх захирал	--1983-1990 улсын шигшээ багт тамирчин --1993-2019 Женко дэд захирал --1995-1998 Brother ХХК захирал --1998-2002 GAG гүйцэтгэх захирал --2002 оноос “Талх- чихэр” ХХК гүйцэтгэх захирал --2008-2011 Чингис Маркет ХХК Ерөнхий захирал	--1982-1991 София ХХК Гүйцэтгэх захирал --1991-2004, --2006 оноос МСВ ХХК Гүйцэтгэх захирал --2004-2006 БГЗБ ХК Гүйцэтгэх захирал	--2005-2006 БГЗБ ХК ерөнхий менежер туслах --2008-2009 GTB ХК Маркетингийн албаны дарга --2009-2012 БНСУ-ын Корес төлөөлөгчийн газар, менежер --2012 оноос Verve Wine ХХК Захирал	--1984-1992 ГЖҮГ-ын авто баазад ахлах нябо --1992-2008 БГЗБ ерөнхий нябо --2008-2016 ЗТХБЯ, ЗТЯ, Сайдын багцын Ерөнхий нябо бөгөөд санхүү хэлтсийн дарга --2016 оноос БГЗБ ерөнхий менежер
Цол зэрэг:	Хөдөлмөрийн хүндэт медаль, Алтан гадас одон	Чөлөөт бөхийн олон улсын хэмжээний мастер		Менежментийн магистр	МУ-ын мэргэшсэн нягтлан бодогч, Гавьяат эдийн засагч
Компанид үзүүлж буй хувь нэмэр	--Аудитын хорооны гишүүн --Нэр дэвшүүлэх хорооны гишүүн	--Шагнал урамшуулал, цалин хөлсний хорооны гишүүн			--Аудитын хорооны гишүүн

## Хараат бус гишүүд

Íýð	Ä.Äàðæàðäàë	Ö.Öýñýäýð	Ä.Öýíäíäðæ
Áíëíàñðíë	Ðíñðíàíí ÓÈÑ, Íààñððëððëëí íàíáæíàíðëëí ñóðäáóóëü	--Íñëääàæëí ÓÀÀÀÄ	--1972-1976 ñ ÍÓÈÑ, --1984-1985 Äáðíàí óëñàà óëñ ð°ðëëí äýýà ñóðäáóóëü --1996 ÒÇÓÒÈ-ëëí óàëðäàà àæëëðàíí ëóðñ
Íýðäýæëë	Ýäëëí çàñàà÷	Öóàäëääàíí äàðàà ñóàëàà÷	Ëíæáíáð, óëñ ð°ð ñóàëàà÷
Äæëíí óóðòëääà	1987-1991 ÍÒÁÄÑ áààø, 1991-2004 íññ ÑÝÇÄÑ-ëëí íðëíà÷ çàðëðäæ, çàðëðäë 1999-2000 ÓÒÄÄ-íí äàðàà	--1962-1972 ÕÁß-íí á°íëë ðóàäëääàíí äàçàð ìýðäýæëëðýí, íðëíà÷ äàðàà --1972-1980 ÄÕß-íí ëíñðò íýääýëä íðëíà÷ äàðàà --1980-1986 ÇÕÕ-à Õóàäëääàíí ð°ë°ë°à÷ëëí äàçàð íðëíà÷ äàðàà --1986-2007 ñíà ÁÄÇÁ ÕÈ-ëëí äàðàà, çàðëðäë, äýà çàðëðäë --2007 íññ ëíñàíëëí ç°àë°ó	--1977-1982 ÓÕÒÝØ ëíæáíáð, çóðäëëí ýëñíàäëðëëí äàðàà --1982-1991 ÍÕÇÝ-ëëí Ò°à óíðñíà àðëàò ðáàðäàðò --1991-1997 ÓÁ óíðíí ÌÀÕÍ-íí óíðñíà àðëàò ðáàðäàðò ÌÕ-íí äð°íðëëí ñàëáíí äýðäýäýð Õììðäëëí ð°ë° çíäýñíëë ç°àë°ëëëí àæëíí àëáííà àðëàò àæëëðàíí, ð°ñëëëí óàëðäàà÷ --1997-2006 Æáíëí ÕÕÈ-à ç°àë°ó
Õíë çýðýà:	Áëçíàñðëëí óàëðäëääàíí ìààëñðò, Ýäëëí çàñàäëëí óðààíí àíëòíð, Ííñíë óëñíí ààüüàð áààø	÷ ëë÷ëëäýýíë äàüüàð àæëëðàí	Ëíæáíáð, ðàðòíëëëí óðààíí ìààëñðò, óëñ ð°ð ñóàëàà÷
Компанид үзүүлж буй хувь нэмэр	Нэр дэвшүүлэх хорооны дарга	Шагнал урамшуулал, цалин хөлсний хорооны дарга	--Нэр дэвшүүлэх хорооны гишүүн

### ТУЗ-ын гишүүдийн хувьцаа эзэмшилт

ТУЗ-ын ердийн гишүүдээс дөрөв нь компанийн 3.2%-аас 16.3% хүртэлх хувийн хувьцааг эзэмшиж байна.



## ҮНЭТ ЦААСНЫ МЭДЭЭЛЭЛ

“Баянгол Зочид Буудал” ХК нь 1964 онд БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн 375 тоот тогтоолын дагуу анхны үйлчилгээг эхлүүлэ байсан түүхтэй. 1991.12.11-ний өдрийн Засгийн газрын өмч хувьчлалын комиссын 27-р тогтоолоор “Баянгол Зочид Буудал ХК” хувийн хэвшлийн аж ахуй болон өөрчлөгдөж анхны хувь нийлүүлсэн зочид буудал болсон байна.

“Баянгол Зочид Буудал” ХК нь 1991 онд ХК болсноосоо хойш хувьцаа эзэмшигч нарт жил бүр тогтмол ноогдол ашиг хувиарлаж байгаа бөгөөд энэ хугацаанд нийт 2 тэрбум төгрөгийн ноогдол ашиг хувиарласан байна.

Дэлхий дахиныг хамраад байгаа цар тахал, түүнтэй холбогдсон хорио цээрийн дэглэмийн улмаас 2020 онд алдагдалтай ажилласан учраас Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2021 оны 02 дугаар сарын 10-ний өдрийн №01 тоот тогтоолоор 2021 онд ноогдол ашиг тараахгүй гэж шийдвэрлэсэн.

Он	Дүрмийн сан /мян.төг/	Нэгж хувьцаанд олгосон ноогдол ашиг/төг/	Нэгж хувьцааны зах зээлийн дундаж үнэ	Хувьцааны тоо
2017	54,998.5	355	34300	423065
2018	54,998.5	355	29900	423065
2019	54,998.5	355	27000	423065
2020	54,998.5	360	27900	423065

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ШИНЖИЛГЭЭ

- 2020 оны эдийн засгийн үзүүлэлтүүд


### Орлогын тайлангийн хандлагын шинжилгээ



2015 оныг суурь он болгож хандлагын шинжилгээг хийсэн ба 2020 онд борлуулалтын орлого суурь оноосоо 80%- иар өссөн, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 118%-иар буурсан, цэвэр ашиг 41%-иар буурсан байна.



## ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТАЛААР:



Тайлангийн үзүүлэлтээс харахад 2016 оноос хойш үндсэн үйл ажиллагааны орлого тогтвортой байсан бөгөөд 2020 онд Дэлхий нийтийг хамарсан цар тахал /covid 19/ ын улмаас шалтгаалан салбарын эдийн засгийн нөхцөл байдал хүндэрч бүрэн зогсонги байдалтай байсан ч бүрэн зогсоохгүйгээр алдагдлыг хамгийн бага түвшинд байхаар ажилласан. Үүнээс үзэхэд үндсэн үйл ажиллагааны орлого 2019 оноос 78%-иар буурсан, нийт зардал 51%-иар буурч улмаар үйл ажиллагааны ашиг буурсан үзүүлэлтэй байна

### ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ХУВЬД 2020 ОНД:

Зочид буудлын салбарын хувьд орлого өмнөх оноос 56%-иар, зардал 41,1%-иар буурсан. Зочид буудалд байрласан зочдын тоо өмнөх онтой харьцуулахад 60%- иар буурч, ор хоногийн тоо 56,9%-иар буурсан.



## 2020 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТАЛААР:

- **Хөрөнгө оруулалтын хувьд:** Үйл ажиллагаагаа өргөжүүлэх, ашиг орлогыг нэмэгдүүлэхийн тулд багагүй хэмжээний хөрөнгө оруулалт хийсэн бөгөөд Төв аймгийн, Эрдэнэ сумын нутаг, “Цонжин болдог”-т байрлах “Баянгол Ресорт” зочид буудлын засвар тохижилтонд зориулж 6,4 тэрбум төгрөгөөр ашиглалтын өмнөх хөрөнгө оруулалтыг хийж улмаар үйл ажиллагаагаа эхлэхэд бэлэн болж байна.





## Хөрөнгө, оруулалт их засвар

№	Хөрөнгө оруулалт, их засвар:	Үнийн дүн /сая ₮/
1	Баянгол рестораны засвар, тохижилт	91,4
2	Б буудлын 10,11,12 давхрын засвар, тохижилт	149,0
3	Монголын нэг өдөр рестораны засвар, тохижилт	41,0
4	Оффисийн засвар, тохижилт	21,0
5	Гадаа тайлбайн цэцэрлэгжүүлэлт	2,0
6	Баянгол рестораны тайз чимэглэлийн тоног төхөөрөмж	26,1
7	“Баянгол Ресорт” ХХК /Зочид буудал, ресорт /	6,400
	Нийт хөрөнгө оруулалтын дүн	6,7 тэрбум

# ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ



Г “БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ний Г  
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо,  
Сүхбаатарын гудамж, Peace Building, 302 тоот  
Утас: 99093541, 88002321; Факс: 976-11-327230;

Цахим шуудан: altantsetseg@sdaudit.mn

2021-03-24

№

СТА/21-22

танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -г

## Г ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН Г

### Дүгнэлт

Бид “Баянгол Зочид Буудал” ХК-ний 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн чухал бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бид “Баянгол Зочид Буудал” ХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (цаашид “СТОУС” гэх)-ын дагуу үнэн зөв, шударгаар илэрхийлж байна гэж дүгнэж байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын Олон Улсын Стандарт (цаашид “АОУС” гэх)-ын дагуу хийж гүйцэтгэв. Уг стандартуудын дагуу бидний хүлээх үүргийг энэхүү тайлангийн Санхүүгийн Тайлангийн Аудиттай холбоотой Аудиторын Үүрэг Хариуцлага гэсэн хэсэгт тусгасан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс баталсан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм (цаашид “НБЁЗОУСЗ-ын дүрэм” гэх)-ийн дагуу Компаниас хараат бус ба эдгээр шаардлагуудын дагуух ёс зүйн бусад үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын баримт нотолгоо нь аудитын дүгнэлт гаргах хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж итгэж байна.

### Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байна. Бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

### Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байж болно. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

# ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ

## **ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)** **Баянгол Зочид Буудал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)**

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

### **Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага**

Удирдлага нь СТОУС-ын дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжтой болгоход зайлшгүй чухал гэж өөрийг тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага Компанийн үйл ажиллагааг зогсоох юмуу татан буулгахаар төлөвлөсөн эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудаа гаргахдаа удирдлага тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэг хариуцлагыг хүлээнэ.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

### **Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага**

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаарх ул үндэслэлтэй нотолгоо олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм.

Ул үндэслэлтэй нотолгоо гэдэг нь өндөр түвшний нотолгоо боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар байгаа материаллаг буруу илэрхийллийг байнга илрүүлдэг гэсэн нотолгоо болохгүй. Буруу илэрхийлэх явдал нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн дараах ажлуудыг хийсэн:

- Санхүүгийн тайланд залилан эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлд тохирохуйц аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн дүгнэлтийнхээ үндэслэл болохуйц хангалттай, тохиромжтой аудитын баримт нотолгоог олж авсан. Зөвхөн нэг алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу илэрхийлэх болон дотоод хяналтыг орхигдуулах явдлууд багтсан байж болно.

# ХӨНДЛӨНГИЙН АУДИТЫН ДҮГНЭЛТ

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ) Баянгол Зочид Буудал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд (үргэлжлэл)

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага (үргэлжлэл)

- Компанийн дотоод хяналтын үр ашигтай байдалд дүгнэлт өгөх зорилгоор бүр тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитын ажилтай холбоотой дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Ашиглагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогуудын нийцэмжтэй байдал, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын ул үндэслэл, удирдлагын гаргасан холбогдох тодруулгыг үнэлдэг.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, мөн олж авсан аудитын баримт нотолгоонд үндэслэн Компанийн тасралтгүй үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал оршин байгаа эсэхийг тодорхойлдог.

Хэрэв материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад анхаарал хандуулах эсвэл ийм тодруулга хийх нь хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын баримт нотолгоонд суурилна. Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг бид бүхэлд нь үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлсэн.

Бид засаглах удирдлагатай зөвхөн аудитын ажлын хамрах хүрээ, цаг хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудын талаар харилцсан.

### Бусад хууль эрх зүйн шаардлагуудын талаарх тайлан

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 92 болон 94-р зүйлийн дагуу бид дараах тохиолдлуудад та бүхэнд тайлагнах үүрэгтэй:

- Сонирхлын зөрчилтэй этгээдтэй хийсэн ажил гүйлгээ;
- Нягтлан бодох бүртгэл хөтлөлт, санхүүгийн тайлан гаргалттай холбоотой зөрчил;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Монголын Хөрөнгийн Биржээс тогтоосон мэдээлэл; болон
- Компанийн дүрмийн дагуу болон аудитын гэрээний дагуу шаардагдах бусад мэдээлэл

Дээрх зүйлстэй холбоотой ямар нэгэн зөрчил илрээгүй болно.

**СЭРЭЛТ ДӨЛ АУДИТ ХХК**  
Мэргэшсэн нягтлан бодогчид

Монгол Улс, Улаанбаатар хот  
Огноо: 2021 оны 3 сарын 24



**Д.АЛТАНЦЭЦЭГ**  
Захирал, МНБ



Анхаарал тавьсанд  
баярлалаа